**ХӨВСГӨЛ АЙМГИЙН**
**УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 25 өдөр Дугаар А/93 Төгөл

# Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 31 дүгээр зүйлийн 31.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26,1, 20 дугаар зүйл 20,1 , Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, Дайчилгааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэг, Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газрын 2024 оны 09 сарын 04-ний өдрийн №37 байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага, сумын Онцгой комиссын 05 дугаар хурлыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр тус сумын Мунгараг багийн "Сар гэрийн гол" гэдэг газар ой хээрийн түймрийн цэг илэрч, ой хээрийн түймэр унтраах бэлтгэл ажлыг дайчилгаагаар хүн хүч, хоол хүнсэнд шаардлагатай байгаа 8,400,000 (зургаан сая нэг зуун мянга төгрөг)-ийг хавсралтаар зарцуулсугай.

2.Батлагдсан зардлыг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (М.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү албаны дарга (Б.Хишигсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА Н.БАТБАЯР

Сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын
05...-ны өдрийн А/93 тоот Захирамжийн
хавсралт

**САР ГЭРИЙН ГОЛ ТҮЙМЭР**

| № | | Тоо | Мөнгөн дүн |
|---|---|---|---|
| 1 | Морины хөлс | 27x230,000 | 6,210,000 |
| 2 | Утасны төлбөр | 1x1,000,000 | 1,000,000 |
| 3 | Хоол хүнс | 1x1,190,000 | 1,190,000 |
| 4 | Нийт дүн | | **8,400,000** |

____________________o0o____________________